

ТҮҮХИЙН ФИЛОСОФИЙН ТУХАЙ ГЕГЕЛИЙН ҮЗЭЛ САНАА

Ш.ГАНХУЯГ

МУИС, НШУС, Философийн тэнхим

Түлхүүр үг: нийгэм, туйлын санаа, хөгжил, эрх чөлөө, оюун санаа, цаг хугацаа

XVIII зууны германы алдарт сонгодог философич Г.Ф.Гегель түүхийг үзэх анхдагч, рефлексив, философийн гэсэн гурван өөр үзэл байна хэмээн үзжээ. Түүхийг үзэх анхдагч үзэл нь түүхэнд болж буй тусгаар үзэгдлүүдийн тухай өгүүлэх бөгөөд тухайн үзэгдэл, үйл явдлыг дөвийлгөн гадаад бусад ертөнцөөс таслан авч үздэгээрээ онцлогтой. Харин рефлексив түүх бичлэгт аль нэг ард түмэн, үндэстэн угсаатан, эсвэл аль нэг цаг хугацааны түүхийг нэгтгэн бусад үзэл санаанаас онцлон өөрийн гэсэн нэгэн үзэл санаагаар тайлбарладаг. Энэ нь прагматик, эсвэл шүүмжлэлт шинжтэй байж болно. Түүхийн философи нь бүх дэлхийн түүхийг нэгдмэл нэгэн түүх болгож үздэгээрээ ялгаатай.

Гегель дэлхийн түүхийг хөгжиж буй процесс гэж үзсэн. Түүний үзлээр түүх дээш дээшээ хөгжсөөр хүрэх ёстой дээд цэг нь "туйлын оюун санаа" юм. Туйлын оюун санаа нь түүхэн хөгжлийн үйл явц дунд илэрч байгаа болно. Иймээс түүхэн үйл явц бүхэн туйлын санаа руу тэмүүлсэн ухаалаг шинж чанартай байдаг. Туйлын оюун санаа бол хамгийн дээд эрх чөлөө мөн бөгөөд материаллаг амьдралтай хэдий хэр их холбогдоно, төдий чинээгээр туйлын санаанаас холдоно, өөрөөр хэлбэл, жинхэнэ эрх чөлөөнөөс холдоно гэж Гегель үзжээ.

Гегелийн үзлээр, түүхэнд цор ганцаар бие даан үүсч хөгжих үзэгдэл, үйл явдал гэж үгүй бөгөөд түүх-нийгмийн бүх үзэгдлүүд өөр хоорондоо салшгүй уялдаа холбоотой явагдана. Нөхцөл шалтгаангүй үүсэх зүйл гэж байхгүй. Харин бүх үзэгдлүүдийн нэгдмэл бүхэл байдал нь л юунаас ч үл хамааран бие даан оршиж болно. Гэхдээ тэрхүү түүхэн нэгдмэл байдал гэдэг нь нэгж үзэгдлүүдийн цуглуулга биш, харин асар нарийн нийлмэл организм юм. Түүхэн тусгаар нэгж үзэгдлүүд нь нэгдмэл бүхэл байдлынхаа аль нэг тал, хэсэг нь болж байдаг учраас тэрхүү нэгж үзэгдлийн мөн чанарыг ухан ойлгох аваас нэгдмэл бүхэл байдлыг нь харж болно. Иймээс түүхэн цаг зуурын, орон зайн хязгаарлагдмал мэт үзэгдлүүд нь үнэн хэрэгтээ нэгдмэл байдал ба олонлогийн илэрхийлэл мөн. Түүхэн олонлогийн тэрхүү нэгдмэл

байдлыг Гегель туйлын оюун санаа хэмээн нэрлэсэн юм. Туйлын оюун санаанд хүргэж ойлгосон цагт л түүхэн үзэгдлийн эрх чөлөөг харж болно.

"Бүх дэлхийн түүх гэдэг бол эрх чөлөөг ухамсарлаж дэвжин дээшлэх хөдөлгөөн мөн бөгөөд түүний зайлшгүй гэдгийг нь бид мэдэх ёстой" хэмээн Гегель "Түүхийн философидоо" бичсэн байна. Түүний үзлээр туйлын санаа, туйлын эрх чөлөө өөрийгөө илрүүлэхийн тулд ямар арга хэрэглэдэг вэ гэсэн асуултад түүхийн үйл явцыг ойлгох хэрэгтэй хэмээн хариулжээ. Мөн энэ талаар Гегель "Түүхийг хамгийн ойроос дөхөж үзэхэд хүмүүсийн үйл ажиллагаа нь тэдний хэрэгцээ, хүсэл сонирхол, зан чанар, авьяас билгээс урган гардаг, улмаар энэхүү драмын жүжгийг тэдгээр хэрэгцээ, дур хүсэл л өдүүлэн гаргаж байгаа бөгөөд тэд л гол үүрэг гүйцэтгэнэ"¹ хэмээн бичсэн байдгаас үзэхүл Гегелийн түүхийн философид хүн нийгмийн аливаа үйл ажиллагааны эхлэл нь хэрэглээ мөн гэсэн үзэл санаа агуулагдаж байна. Гэхдээ "энэхүү хэмжээлшгүй их хүсэл, сонирхол, үйл ажиллагаанууд нь өөрийнхөө зорилгодоо хүрэх гэсэн, түүнийг ухамсартай болгож хэрэгжүүлэх гэсэн ертөнцийн оюун санааны зэвсэг мөн бөгөөд уг зорилго нь өөрийгөө олох, өөртөө очих, өөрийгөө үйл хэрэг хэмээн бясалгахад оршино"² гэсэн байдаг.

Түүнчлэн "Бүх дэлхийн түүх нь үзэл санаа болон байгаль орон зайд хэрхэн илэрдэг шиг ерөнхийдөө туйлын санааны цаг хугацаан дахь илрэл юм". Түүхэн хөгжлийн ухаалаг бодит байдалтай эвлэрэх ёстой. Эрх чөлөөг ухамсарлах ухамсрын өсөлт нь улс төрийн үйл ажиллагаагаар тодорхойлогдоно. Аливаа улс төрийн үйл ажиллагаа нь ямагт зайлшгүй бодит байдал, туйлын санаанд нийцэж байх ёстой. "Бодтой байгаа юм бүхэн оюун ухаанд зохистой байдаг бөгөөд оюун ухаанд зохистой бүхэн нь бодит байдал болдог" хэмээн Гегель бичсэн байна.

Түүхэн бодит байдал гэдэг нь Гегелийн хувьд эмпирик бодит байдал буюу түүхэн баримт биш юм. Түүхэн баримт бүхэн нь түүхэн нэгдмэл байдлын аль нэг тал шинж, бүрэлдэл хэсэг нь болдог учраас л түүхэн нэгж тусгаар үзэгдэл бүхнийг ухаалаг шинж чанартай гэсэн хэрэг болно. Иймээс Гегель түүхэн бодит байдал гэдгийг түүхэн ухаалаг үзэгдэл гэсэн утгаар хэрэглэжээ. Тэгээд ч Гегель "байгаа бүхэн зөв зүйтэй" гэсэн дүгнэлт хийсэн байдаг.

Гегель тэрхүү түүхэн нарийн нийлмэл бодит байдлыг "туйлын оюун санаа", эсвэл "туйлын бодит байдал" хэмээн нэрлэсэн хэрэг юм. Туйлын

¹ Г.Ф.Гегель. Философия истории. Санкт-Петербург. 1993 с.73

² Мөн гэнд. 77 дахь тал

бодит байдал ямагт санаалаг буюу ухаалаг байна гэж үзснийг нь объектив идеалист үзэл хэмээн тодорхойлдог. Гегелийн логик дүгнэлтээр түүхэн бодит байдлын шинж төрх нь нэгдмэл, ямар ч зөрчилгүй үзэл бодлоос урган гарах ёстой. Гэтэл түүх-нийгмийн тусгаар үзэгдлүүд нь ямагт өөртөө зөрчилтэй байдаг. Тэрхүү зөрчлөөс дараа дазаагийн үйл явдлууд урган гарна. Тэдгээр нь зөвхөн нэгдмэл байдалдаа л зөрчилгүй болно. Иймээс түүхэн үзэгдлүүдийн зөрчилгүй болсон нэгдмэл байдлыг "туйлын оюун санаа" хэмээн нэрлэсэн байна. Туйлын санаанд нь хүртэл ухаараагүй түүхэн тусгаар үзэгдэл гэдэг бол жинхэнэ үнэн бодит байдал биш. Түүхийн үнэн гэдгийг түүхэн нэгдмэл байдлаар нь ухаарсан цагт л тодорхой болно. Түүхэнд тусгаар баримтууд гэж байхгүй, зөвхөн нэгдмэл байдал л бодьтой оршино хэмээн Гегель үзжээ.

Түүхэн үйл явц гэдэг бол үр дүнг нь ойггоход зориулагдсан үзэгдэл юм. Үзэгдлүүд нь нэгээс нөгөө нь урган гарч байдаг тасралтгүй хөгжилд оршино. Эцсийн нэгдмэл байдалд хүртлээ түүхэн үзэгдлүүд нь жинхэнэ үнэн болж чадахгүй. Түүхийн нэгдмэл бодит байдлыг ухаарсан ухаарлыг л үнэн гэж хэлж болно. Иймээс түүхэн үйл явц гэдэг бол туйлын санаа өөрөө өөрийгөө ухаарч буй түүхэн хөгжил юм. Иймээс түүх гэдэг бол ухаарлын бурхан мөн.

Цаг зуурын түүхэн үзэгдлүүд нь боловсронгуй биш байдлаас боловсронгуй байдал руу шилжиж буй үйл явц юм. Энэ талаар "Оюун ухааны ертөнц ба өөрийгөө ухамсарласан дур зорго нь санамсаргүй тохиолдолд өртдөггүй, харин өөрийгөө мэдсэн үзэл санааны гэрэлд илрэн гардаг". Тэрхүү үр дүнг ухаарвал түүхийн нэгдмэл байдлыг олж харна гэсэн үг гэх зэргээр Гегель "Түүхийн философидоо" бичсэн байдаг.

Гегелийн үзлээр, оюун санаа болон түүний хөгжих үйл явц нь түүхийн философийн судлах зүйл болно. Оюун санааны шинж төрхийг түүний эсрэг тал болох материаллаг байдалд сөргүүлэн тавьснаар ойлгож болно. Материаллаг байдал нь ямагт хүнд бэрх шинж чанар луу тэмүүлж байдаг бол оюун санаа нь ямагт эрх чөлөө рүү тэмүүлнэ. Материаллаг байдал нь өөрийнхөө гадна байгаа зүйлийг зорино, харин оюун санаа нь өөрийн дотор байгаа зүйл рүүгээ л хандана. "Оюун санаа бол өөртөө байгаа ахуй" гэж Гегель тодорхойлсон байдаг. Оюун санаа нь ямар ч зөрчилгүйгээр өөрөө өөртэйгээ туйлын адилхан болсон цагт түүхэн хөгжил эцсийн цэгтээ хүрнэ гэсэн үг.

Түүний үзлээр хүн төрөлхтний түүхэн хөгжил нь дорнын, грек-ромьн, германы гэсэн гурван үе шатыг туулжээ. Цаашилбал, "Дорно дахины ард түмэн нэг л хүн эрх чөлөөтэй гэдгийг мэдсэн, Грек Ромын ертөнц нь нэг хэсэг нь эрх чөлөөтэй гэдгийг мэдсэн, харин бид (германчууд) бүх хүн өөрөө өөртөө эрх чөлөөтэй, өөрөөр хэлбэл хүн гэдгээ мэдсэн - эндээс бүх дэлхийн түүхийг хэрхэн ангилах вэ, улмаар бид түүнийг хэрхэн авч үзэх вэ гэдэг нь харагдаж байна"¹ хэмээн Гегель бичсэн байдаг. Тэрээр дарангуйлагч засаг зөвхөн нэг хүний эрх чөлөөг, Грек Ромын нийгмийн харилцаан дахь ардчилал нь зөвхөн нэг хэсэгт л эрх чөлөөг мэдрүүлдэг бол хаант засаг нь бүхний эрх чөлөөг хангана гэж үзсэн байна. Гэхдээ Гегелийн хувьд хууль ёсгүй эрх чөлөө гэж байж болохгүй бөгөөд хууль ёс байгаа газарт л эрх чөлөө байна. Иймээс эрх чөлөө гэдэг бол хууль ёсыг даган мөрдөх эрх юм.

Гегель яагаад дэлхийн түүхэн хөгжилд германы үүрэг ролийг тийнхүү өндөр өргөсөн бэ гэдэг асуудал өнөөг хүртэл философичдын дунд маргаантай хэвээр байсаар байна. "Германы окун ухаан бол эрх чөлөөний, агуулга нь өөрөө туйлын хэлбэр болж байдаг тэрхүү эрх чөлөөний өөрийгөө хязгааргүй тодорхойлж байгаа үйл явц болох туйлын санааг хэрэгжүүлэх эцсийн зорилготой шинэ ертөнцийн оюун ухаан юм"² хэмээн Гегель бичжээ. Оюун санаа өөрөө өөртөө хууль тогтоож байгаа нь тэр эрх чөлөөтэй байгаагийн илэрхийлэл мөн. Хуулийг тогтоогч ба хуулийг мөрдөгчийн хооронд ялгаа байх ёсгүй бөгөөд бүгд хууль тогтоогч, бүгд хууль мөрдөгч байх ёстой. Түгээмэл дур зорго ба бүхний дур зорго хоёр нь ялгаатай ойлголтууд юм. Эзэн хаан түгээмэл дур зоргыг, харин ардчилал нь бүхний дур зоргыг илэрхийлнэ.

Гегелийн үзлээр, Германы нийгэм нь Их Карлыг хүртлэх үе, Их Карлаас Шинэчлэл (Реформац) хүртлэх үе, Шинэчлэлээс хойшхи үе гэсэн түүхэн гурван үе шатыг туулжээ. Энэ нь Эцэг, Хүү, Ариун оюун санаа гэсэн христос шашны гурван үечлэлд тохирдог байна. Гегелийн энэ тайлбар нь түүний герман сургалтаар хүмүүжсэнтэй холбоотой гэж үзэх судлаачид байдаг. Гегелийн амьдарч байсан цаг үед Германы нийгмийн байдлыг нэг хэсэг нь хоцрогдсон гэж тодорхойлж байхад нэгөө хэсэг нь ирээдүйн цаг хугацааг зөгнөгч хэмээн тодорхойлдог байжээ. Энэ нь өнөө үед Хятадын байдлыг янз бүрээр тодорхойлдогтой төстэй юм. Ямар ч атугай Гегелийн үзэлд Герман эх орноо дээдлэх эх оронч үзэл санаа нуугдаж байгаа бөгөөд хүн төрөлхөтний түгээмэл түүхийг өөрийн орноосоо төлөөлүүлэн ухаарах эх

¹ мөн тэнд. 72 дахь тал

² мөн тэнд. 361 дахь тал

оронч үзлээс бүх хүн төрөлхөтнийг ойлгох ухаарал эхлэнэ гэсэн санааг агуулж байгаа болно.

Гегелийн түүхийн философийн үзэлд дэлхийн түүхэн хөгжлийг үечлэсэн үечлэлээс түүхэн хөгжлийг нэгдмэл туйлын оюун санаа руу тэмүүлсэн үйл явц гэж үзсэн түүний үзэл нь дараа дараагийн философийн түүхэнд илүү үүрэг гүйцэтгэсэн гэдгийг онцлон тэмдэглэвэл зохино. Иймээс ч Гегелийн үзэл санаанаас эх авсан дараагийн үеийн марксист болон иррационал чиглэлийн философичид түүхийн философийн асуудал дээр дэлхийн түүхийг үечлэсэн үечлэлээс нь илүү туйлын оюун санаа руу тэмүүлсэн хөгжлийн тухай сургаалыг нь илүү хэлэлцэн хөгжүүлсэн байдаг.

Гегелийн үзлээр түүхэн хөгжлийн хамгийн гол зарчим бол үндэсний ухамсар юм. Цаг үе бүхэнд ирээдүй рүү хөтөлсөн аль нэг тодорхой үндэстэн байдаг. Тэндээс тухайн цаг үеийн баатрууд төрөн гарч хэвшмэл ёсыг хуулийн дагуу халдаг. Ийм жишээнд Александр, Цезарь, Наполеон нарыг дурдсан байна. Гегель үндэсний ухамсрыг өргөн магтахдаа эрх чөлөөг төрт ёстой нэгтгэн тайлбарласан байдаг. Шинэчлэлийн (Реформацийн) үеэс төрт ёсны харилцаа жинхэнэ утгаар тогтсон гэж тэрээр үзжээ. Ромын үед эзэн хааныг бурхан мэт тахиж төрийг ариун шинжтэй хэмээн ухаарч байв. Харин дундад зууны үед шашныг төрөөс дээгүүр тавьсан байна. Христос шашныг шинэтгэгч Мартин Лютер, түүний дараагаар Гоубс, Спиноза, Руссо, Гегель нар төрийг шашнаас дээгүүр тавих санал дэвшүүлсэн юм. Гегелийн үзлээр зөвхөн төр л хүмүүсийн хоорондох ёс суртахууны зөв зохистой харилцааг тогтоож чадна. Төрөөс тогтоох хууль нь бүхний нэгдмэл чанарыг агуулж байх ёстой. "Төр бол ухаалаг, өөрийгөө объективээр ухамсарлаж өөрөө өөртөө байх эрх чөлөө мөн... Төр бол хүний дур зорго, эрх чөлөөний хэлбэрээр илэрдэг оюун санааны үзэл мөн"¹ хэмээн Гегель бичжээ. Иймээс бүх хүн төрийн хуулийг дээдлэх хэрэгтэй гэсэн үзлийг гаргасан байдаг. Ингэвэл бүгд эрх чөлөөтэй болно.

¹ мөн гэнд. 97 дахь тал

Дүгнэлт

Г.Ф.Гегель түүхийн философи нь бүх дэлхийн түүхийг нэгдмэл нэгэн түүх болгож үздэгээрээ ялгаатай хэмээн үзжээ. Түүний үзлээр түүхэн цаг зуурын, орон зайн хязгаарлагдмал мэт үзэгдлүүд нь үнэн хэрэгтээ нэгдмэл байдал ба олонлогийн илэрхийлэл мөн. Түүхэн олонлогийн тэрхүү нэгдмэл байдлыг Гегель туйлын оюун санаа хэмээн нэрлэжээ. Түүхэн баримт бүхэн нь түүхэн нэгдмэл байдлын аль нэг тал шинж, бүрэлдэл хэсэг нь болдог учраас л түүхэн нэгж тусгаар үзэгдэл бүхнийг ухаалаг шинж чанартай гэж Гегель тодорхойлсон болно. Туйлын бодит байдал ямагт санаалаг буюу ухаалаг байна гэж үзснийг нь объектив идеалист үзэл хэмээн тодорхойлдог. Туйлын санаанд нь хүртэл ухаараагүй түүхэн тусгаар үзэгдэл гэдэг бол жинхэнэ үнэн бодит байдал биш. Түүхэнд тусгаар баримтууд гэж байхгүй, зөвхөн нэгдмэл байдал л бодтой оршино. Цаг зуурын түүхэн үзэгдлүүд нь боловсронгуй биш байдлаас боловсронгуй байдал руу шилжиж буй үйл явц юм. Түүхэн хөгжлийн хамгийн гол зарчим бол үндэсний ухамсар мөн бөгөөд цаг үе бүхэнд ирээдүй рүү хөтөлсөн аль нэг тодорхой үндэстэн байдаг хэмээн Гегель үзжээ.

Ашигласан ном зохиол

- Г.В.Гегель. Философия истории. Спб. 1993.
- Ш.Ганхуяг, М.Гантуяа. Философийн түүхэн тойм. УБ., 2002.
- А.Энхбаатар. Некоторые проблемы монголоведения в философии Гегеля. /Автореферат/УБ., 2005.